

## **Нягтлан бодох бүртгэлийн дадлагын сургалтын практикт мэдээллийн технологийг үр дүнтэй ашиглах нь**

### **Information Technology Usage in Accounting Education and Accounting Practice Learning**

Д. Авирмэд<sup>1</sup>, Б. Алтан-Эрдэнэ<sup>2</sup>, Б. Хүрэлбаатар<sup>3</sup>

#### Хураангуй

Бизнесийн үйл ажиллагаа өргөжин тэлж, удирдлагын бүхий л хүрээнд мэдээллийн технологийг ашиглах болсон. Энэ нь тэнд ажиллах боловсон хүчний мэдлэг чадварыг нэмэгдүүлэх хэрэгцээг бий болгож байна. Орчин үед нягтлан бодогчид зөвхөн бүртгэх, тооцоолох ажлыг гүйцэтгэх бус санхүү, бүртгэлийн программ хангамж болон мэдээллийн технологийн хэрэгслийг ашиглаж чаддаг, бүртгэлээр бий болсон мэдээллийг шийдвэр гаргалтандаа ашиглаж чаддаг, тасралтгүй сурч, хөгжих чадваруудыг эзэмшсэн байх шаардлагууд тавигдах болжээ. Ийм шаардлагуудыг биелүүлэх нэг арга зам нь нягтлан бодох бүртгэлийн чиглэлийн их, дээд сургуулийн сургалтанд мэдээллийн технологийг үр дүнтэй ашиглах явдал юм. Энэхүү судалгааны ажлын хүрээнд дадлагын сургалтын онлайн программ нэвтрүүлэн туршилт хийж, үр дүнг тодорхойлсон болно.

*Түлхүүр үгс:* мэдээллийн технологи, дадлагын сургалт, онлайн платформ, программ хангамж

#### Abstract

Information Technology (IT) has become a vital and integral part of every business. From multi-national corporations to small businesses, IT plays a key role. This situation creates the need for skilled personnel. Nowadays, accountants need to be able - to use accounting software and IT tools, to use the information they generate in their decision-making, and to acquire the skills to continuously learn and develop. One way to meet such requirements is to use IT efficiently in accounting education and accounting practice learning in universities and colleges. In this study, we introduce a practical online platform and test the results.

*Keywords:* information technology, practice learning, online platform, accounting software

---

<sup>1</sup> МУИС-ийн Бизнесийн Сургууль, Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн багш, доктор  
E-mail: avirmedd@yahoo.com

<sup>2</sup> МУИС-ийн Бизнесийн Сургууль, Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн багш, доктор  
E-mail: altanerdene.b@num.edu.mn

<sup>3</sup> МУИС-ийн Бизнесийн Сургууль, Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн багш  
E-mail: khurelbaatar@num.edu.mn

## Үндсэн хэсэг


Мэдээллийн технологи (МТ) асар хурдацтай хөгжиж байгаа өнөө үед энэ салбарын ололтыг бусад салбарт амжилттай хэрэглэх соёл нэгэнт төлөвшжээ. Нягтлан бодох бүртгэл (НББ) тооцооллыг компьютер, программчлалгүйгээр төсөөлөх аргагүй болсон өнөө үед нягтлан бодогчдын хувьд техникийн ур чадварын чухал хэсэг нь компьютер болоод байна.

Бизнесийн үйл ажиллагаа, гадаад дотоод харилцаа хөгжихийн хэрээр байгууллагууд өргөжин тэлж, бүртгэл санхүүгийн салбар хөгжиж байдаг зүй тогтолтой. Монгол улсын хувьд анх 1993 онд “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийг баталж байсан бол өнөөдөр нийгмийн хөгжлийн шаардлагаар тус хууль болон “Цахим гарын үсгийн тухай хууль”, “Татварын

багц хуулиудад” удаа дараагийн өөрчлөлт оруулж, өнөөдрийн байдлаар санхүүгийн болон татварын тайлангуудыг цахим хэлбэрээр тушаах, баталгаажуулах нөхцөл бүрдсэн<sup>4</sup> нь НББ, тайлагналын системд мэдээллийн технологийн дэвшлийн ашиглалтыг төрийн зүгээс дэмжиж байгаагийн илрэл юм.

Ийнхүү нягтлан бодох бүртгэлд мэдээллийн технологийг ашиглах, бүртгэлийн программын ашиглалтыг нэмэгдүүлэх, хөгжүүлэх эрх зүйн таатай орчин бүрдсэн гэж үзэж байна. Энэ нь нэг талаас аж ахуйн нэгжүүдийн худалдан авах бүртгэлийн программын шаардлага болоод зогсохгүй нөгөө талаас нягтлан бодох бүртгэлийн программ хөгжүүлэгч компаниудын бүтээгдэхүүний чанарын баталгааг бий болгосоор иржээ.

Дүрслэл 1. Дотоодын зах зээлд нийтлэг хэрэглэгдэж буй нягтлан бодох бүртгэлийн программууд



Эх сурвалж: Судлаачдын нэгтгэл

<sup>4</sup> 2015.06.19-ний өдөр шинэчлэн найруулсан Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангаа энэ хуулиар тогтоосон хугацаанд харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлэх үүрэгтэй" гэж заасан бөгөөд энэхүү заалтыг Сангийн сайдын 2014.09.22-ны өдрийн 201 тоот тушаалын нэгдүгээр хавсралт "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авах, хянах, нэгтгэл хийх, мэдээллийг ашиглах журам"-аар зохицуулж байна.

“Интерактив” ХХК нь анх 1996 онд дотоодын зах зээлд, Монгол хэл дээр ашиглах боломжтой нягтлан бодох бүртгэлийн программыг танилцуулж байснаас хойш энэ салбарт хоорондоо өрсөлдөхүйц олон программууд бүтээгджээ (Дүрслэл 1).

Энэхүү нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийн бүтээгдэхүүний зориулалтаас харвал жижиг, дунд аж ахуйн нэгжийн санхүүгийн бүртгэлд зориулагдсан программ 36% (жижиг, дунд аж ахуйн нэгжид зориулагдсан зөвхөн санхүүгийн тайлан гаргахад чиглэсэн программ 21%, дээр нь жижиг, дунд аж ахуйн нэгжийн бүртгэлд зориулсан онлайн программ 15%) хамгийн их нийлүүлэгдсэн байна.

Үүний дараагаар Intuit Quick Books, Open Enterprise Resource Planning (OERP), ERA ERP, Ellipse ERP зэрэг гадаад программ хангамжууд орж байгаа бөгөөд Intuit Quick Books нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын төсөл хөтөлбөрийн хүрээнд их хэрэглээтэй байгаа бол Оюу толгой ХХК Ellipse ERP, Эрдэнэт УБҮ ERA ERP зэргээр үйл ажиллагааны онцлогт нийцүүлсэн программуудыг ашиглаж байна.

Төрийн байгууллагууд нь “Төсвийн тухай” хууль, УСНББОУС, тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу Төсвийн шууд захирагч, Төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр болон Засгийн газрын түвшинд нэгтгэж, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэдэг зэрэг онцлогтой тул “Санхүүгийн тооцоолох системс” ХХК-ийн гурван бүтээгдэхүүнийг зонхилон хэрэглэж байна.

Том аж ахуйн нэгжид зориулагдсан программ нь байгууллагын үйл ажиллагааг бүхэлд нь мэдээллээр удирдах (ERP)-ад чиглэсэн цогц системиг хөгжүүлж байгаа бөгөөд үүнд нягтлан бодох бүртгэлээс гадна хүний нөөц, агуулах, хөрөнгийн удирдлага, харилцагчийн хамаарлын (Customer Relationship Management-CRM) удирдлага зэрэг өргөн цар хүрээтэй агуулгаар хөгжүүлж байгаа нь мэдээллийн технологийн хөгжлийн хамгийн сүүлийн үеийн ололтод тулгуурлаж байна.

“Интерактив” ХХК хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид зориулсан бүртгэлийн программыг боловсруулан зах зээлд гаргасан явдал нь анх удаа нягтлан

Дүрслэл 2. НББ-ийн практикт мэдээллийн технологийн хэрэглээ, чиг хандлага

|   | Механик тооцооллын үе  | Электрон тооцооллын үе  |                                      |                                      |
|---|--|---|--------------------------------------|--------------------------------------|
| Тооцоолол ашиглаж буй хэрэгсэл                      | Мод, чулуунд хэрчлээс гаргах<br>Сампин /мөхлөг/<br>Механик тооны машин | Цахилгаан тооны машин<br>Электрон тооны машин<br>Персональ компьютер<br>Ухаалаг төхөөрөмж |                                      |                                      |
| Хамаарах хугацаа                                    | Балар эртнээс – МЭ1980-аад он  | 1980-аад оны сүүлээс өнөөг хүртэл   |                                      |                                      |
| Манай улсын НББ-ийн программын хөгжлийн түүхэн үеүд |  | 1996-2008   | 2008-2013                            | 2013-2018                            |
| Нягтлан бодох бүртгэлийн программын хөгжлийн чиглэл |  | Зөвхөн нягтлан бодох бүртгэлийн программ  | Байгууллагын нөөцийн цогц систем ERP | Үүлэн тооцоолол буюу онлайн хувилбар |

Эх сурвалж: Судлаачид

бодох бүртгэлийн программыг таниулсан бүтээгдэхүүн болж байсан. Үүний дараагаар 1998 онд Ординат ХХК нь “Винница”, Санхүүгийн тооцоолох ХХК нь “Acolous”, Инфосистемс ХХК нь “MACS” санхүүгийн программыг зах зээлд нэвтрүүлсэн нь бүгд нягтлан бодох бүртгэл хөтлөөд санхүүгийн тайлан гаргах зориулалттай, бүх орцын мэдээллийг гараас оруулдаг программууд байв.

Нягтлан бодох бүртгэлийн программын хөгжлийг мөн “Интерактив” ХХК дараагийн шатанд гарган хөгжүүлсэн нь Interactive Diamond ERP систем байлаа. ERP системийн давуу тал нь цаг бүртгэл, POS-ын бүртгэлийн төхөөрөмжтэй холбогдох, мэдээлэл оруулалтыг автоматжуулах давуу талтай болсны дээр зөвхөн нягтлан бодох бүртгэлийн явцуу хүрээнээс гарч агуулах, хүний нөөцийн удирдлага зэргийг хамруулсан байгууллагын үйл ажиллагааны бүхий л мэдээллийн нөөцөөр хангахад зориулагдаж байлаа. Эдгээр программуудын хөгжилд түлхэц үзүүлсэн нэг зүйл бол байгууллагын үйл ажиллагааны чиглэл байсан бөгөөд зочид буудал, ресторан, худалдаа, үйлдвэрлэл, банк, даатгал зэрэг чиглэлд салбарын онцлогийг харгалзан хөгжүүлэх боломж байсан нь олон төрлийн өрсөлдөх программ бий болох шалтгаан болж байв.

Нягтлан бодох бүртгэл дэх мэдээллийн технологийн хөгжил нь ухаалаг төхөөрөмжийн тусламжтайгаар улам бүр хэрэглээнд ойртож байгаагийн нэг илрэл нь АТМ-аас мөнгө авах, цахимаар гүйлгээ хийх боломжийг бидэнд олгож байгаа явдал юм. Энэ нь мэдээллийн технологийн хөгжил нягтлан бодох бүртгэлийн салбарт хүний хөдөлмөрийг орлох хэмжээнд хүртэл хөгжиж байгааг харуулна. Дээрх бодит нөхцөл байдал нь интернэтийн хэрэглээ

(цахим худалдаа, сошиал медиа), үүлэн тооцоолол (Cloud Computing) нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг онлайн орчинд ажилладаг байхыг шаардаж байна.


Манай улсад анхны онлайн нягтлан бодох бүртгэлийн Baaz.mn программыг 2013 онд “Нова софт” ХХК үүлэн тооцооллын технологид тулгуурлан зохион бүтээсэн бөгөөд энэхүү жижиг, дунд байгууллагад зориулсан программ нь нягтлан бодох бүртгэлийн программын хөгжлийн өнөөгийн дүр төрхийг тодорхойлж байна. Энэхүү программыг дагаад Erhet.mn, Ruby.mn, Unicus зэрэг программуудыг зах зээлд нийлүүлж байна.

Мэдээллийн технологи хурдацтай хөгжиж, байгууллагын үйл ажиллагаа, цар хүрээ өргөжин тэлэхийн хэрээр нягтлан бодогчдод байгууллагын мэдээллийн системийн төлөвлөлт, зохион байгуулалт, хамгаалалт, хяналт, найдвартай байдал зэрэг олон мэдлэг шаардлагатай болж иржээ. Ийнхүү бодит эрэлт хэрэгцээ үүссэн тул нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулиуд нягтлан бодогч-мэдээлэл зүйн чиглэлээр хосолсон мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн нь дээд боловсролын сургалтын агуулгад ахиц дэвшлийг авчирсан юм.

Бид судалгааны ажлынхаа хүрээнд нягтлан бодогчдод тавигдаж буй гол шаардлагыг тодорхойлох үүднээс 2017-2018 онд зарлагдсан төрийн болон хувийн хэвшлийн, гадаад дотоодын 200 гаруй байгууллагын ажлын байрны албан ёсны зарын мэдээлэлд баримтын судалгаа хийж дүгнэлт гаргалаа.

Судалгаанаас үзвэл ажил олгогчид нягтлан бодогч нарт зөвхөн мэргэжлийн ур чадвараас гадна маш олон талын шалгуурыг тавьж байгаа нь нягтлан

Дүрслэл 3. “Нягтлан бодогч” ажлын байранд тавигдаж буй шаардлага



Эх сурвалж: Ажлын байрны сонгон шалгаруулалтын баримтын судалгааны дүн, судлаачдын нэгтгэсэнээр

бодогчийн ажил бол хариуцлагатай, нэр хүндтэй болохыг илтгэнэ.

Нягтлан бодогчоор ажиллах хүн юуны өмнө дадлага туршлагатай (69.1%), программын мэдлэгтэй (50% орчим), бие дааж ажиллах чадвартай (42%), мэргэжлийн ёс зүйтэй (35%), хариуцлагатай байх (39%) хэрэгтэй гэжээ.

Эдгээр шаардлагуудаас ажлын дадлага туршлагаас бусад чадварыг их, дээд сургуульд суралцах хугацаандаа эзэмшсэн байх боломжтой юм. Ийнхүү санхүү, бүртгэлийн программын мэдлэгийн эрэлт хэрэгцээ өндөр байна гэж дүгнэлээ.

Мэргэжилтнээс шаардаж буй мэдээлэл технологийн мэдлэгийн 20% нь оффисийн хэрэглээний программ хангамж дээр сайн ажилладаг байх, санхүүгийн программ дээр ажилладаг байх, Diamond программ дээр ажилладаг бол давуу тал болно зэргээр ажиллах программын нэрийг шууд заасан шаардлагууд ч байна.

Нягтлан бодогчдын Олон улсын холбооны Боловсролын хороо НББ-ийн чиглэлийн их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт мэдээллийн технологийн чиглэлийн хичээлүүдийг оруулах санаачлагыг 1995 онд гаргасан. Олон улсын хэмжээнд үйлдлийн систем, МТ-ийн удирдлага, МТ-ийн стратеги, МТ-ийн дотоод хяналт, МТ-ийн хөгжүүлэлт зэрэг хичээлүүдийг нягтлан бодогч мэргэжлийн сургалтын хөтөлбөрт оруулдаг байна.

Манай практикт нягтлан бодогч мэргэжилтэн бэлтгэж буй их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт нийтлэг байдлаар НББ-ийн мэдээллийн систем (онолын мэдлэг олгох), НББ-ийн программ (дадлага олгоход чиглэсэн) хичээл тус бүр 3 багц цагийн агуулгын хүрээнд орж байна.

Ихэнх их, дээд сургуулиуд НББ-ийн программыг гэрээгээр худалдан авч суурилуулан НББ-ийн программын хичээлийг орж байгаа нь оюутнуудад олон

төрлийн программыг туршиж үзэх, нэг программыг бүрэн эзэмших хангалттай мэдлэгийг олгож чадахгүй байна. Түүнчлэн ийм программыг хөгжүүлэх, арилжааны эргэлтэнд оруулж орлого олох боломжгүй, сургуулийн хувьд зардлыг нэмэгдүүлэх зэрэг дутагдалтай талуудыг дурьдаж болохоор байна.

Сургалтын хөтөлбөрт тусгагдсан

мэргэжлийн дадлагын хүрээнд оюутнууд гэрээт байгууллагын санхүүгийн программ дээр ажиллах боломж бага (ихэвчлэн боломжгүй) байдаг нь энэ чиглэлийн ур чадварыг дэмжиж чаддаггүй.

НББ-ийн ангийн оюутнуудаас онол, практикийн уялдаа холбоог илэрхийлэх зорилгоор ярилцлагын аргаар авсан судалгааны үр дүнг авч үзье.

Дүрслэл 4. НББ-ийн дадлага хийх явцад тулгарч байсан бэрхшээлүүд (давхардсан тоогоор)



**Эх сурвалж:** НББ-ийн төгсөх ангийн оюутнуудаас үйлдвэрлэлийн дадлагын талаар ярилцлагын аргаар авсан судалгааны үр дүн, судлаачдын нэгтгэсэнээр

Эндээс, мэргэжлийн болон үйлдвэрлэлийн дадлага хийж буй оюутнуудын хувьд онолын мэдлэгээ практикт шууд буулган хэрэглэхэд зааварчилгаа хэрэгтэй, тэд багш нараас асууж судалдаг шигээ бусад хүмүүсээс асууж мэдлэг олж авч хараахан чадахгүй, удирдаж буй ажилтан ч зааж сургах, ойлгуулах дадлага туршлага хангалтгүй байдаг нь дадлагыг 100 хувь үр дүнтэй болгож хараахан чаддаггүй гэж хэлж болохоор байгаа юм.

Түүнчлэн НББ-ийн программ хангамж дээр ажиллаж дадлагажих боломжгүй,

зарим тохиолдолд ажиллахыг зөвшөөрсөн ч оюутан тэнд бие дааж гүйлгээ хийж чадахгүй, удирдагчаас тусламж хүсэхээс эмээдэг, тэнхимээс томилогдсон удирдагч багштайгаа нягт холбоотой байж чаддаггүй зэрэг хүндрэлүүд байдаг байна. Ийнхүү дадлагын үед багш оюутанд шууд туслалцаа үзүүлдэг байх, программ хангамж дээр олон хувилбараар ажиллах боломжийг оюутанд олгох, оюутныг бие даан ажиллахад сургах зэрэг олон талын хэрэгцээ шаардлага байна гэсэн дүгнэлтэнд хүрлээ.

НББ-ийн мэргэжлээр суралцах хугацаанд олж авсан мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх нь тэдний үнэлэмжийг өсгөх, мэргэжлийн нэр хүндийг нэмэгдүүлэх, цаашлаад цаг хугацаа хэмнэх зэрэг олон талын ач холбогдолтой.

Ийнхүү онолын болон практик судалгааны дүгнэлтэд үндэслэн цаг үеийн болон нийгмийн зайлшгүй шаардлагын үүднээс нягтлан бодох бүртгэлийн дадлагын сургалтанд мэдээллийн технологийг үр дүнтэй ашиглах хэрэгтэй гэж үзсэнээр бид онлайн платформ, программ боловсрууллаа.

Энэхүү онлайн платформ нь ажил гүйлгээг бүртгэж буй дансны харилцааны мөн чанарыг ойлгох, дансны харилцааг хийж байхдаа суралцагч шаардлагатай тусламж дэмжлэгийг багшаас шууд авч байхаар зохион байгуулагдсан нь хэрэглэгчдийн хувьд амар хялбар гэдгээрээ давуу талтай юм.

Түүнчлэн уг программыг сургалтын орчин үеийн хэрэглэгдэхүүн болгон цаашид хөгжүүлэх, арилжааны эргэлтэнд оруулах боломжтой зэргээр судалгааны ажлын ач холбогдол, үр дүн илэрч байгаа юм.

#### Дүгнэлт

Шинжлэх ухаан, технологийн хурдацтай хөгжлийн эрин үед аль ч салбарын, тухайлбал нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтнүүдийн үйл ажиллагааны цар хүрээ хязгааргүй өргөжин тэлж, шинэ шинэ үүрэг зорилгууд бий болж, шинэ мэдлэгийг шаардах болжээ. Энэхүү шинэ

орон зайг дүүргэх нягтлан бодогчдыг бэлтгэн гаргахад дадлагын сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсронгуй болгох эрэлт хэрэгцээ үүсч байна. Энд олон хүчин зүйлсийн нөлөөллийг авч үзэх шаардлагатай ба энэхүү судалгааны ажлын хүрээнд онлайн программ боловсруулан туршсан болно.

Дадлагын сургалтанд онлайн программыг нэвтрүүлснээр суралцагсдад эзэмшүүлэх мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, уг программ хангамжийг хөгжүүлэн мэргэжилтнүүдийн тасралтгүй суралцах боломжийг олгох, өмчлөгчдийн хувьд зах зээлд эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүн болгон нийлүүлэх боломжтой зэргээр судалгааны ажлын ач холбогдол илэрнэ.

#### Санал зөвлөмж

Энэхүү судалгааны ажлын хүрээнд боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн онлайн программыг сургалтын хэрэглэгдэхүүн болгон цаашид үр дүнтэй ашиглахад дараах нөхцлүүд шаардагдах тул холбогдох талууд анхаарал хандуулах нь зүйтэй. Үүнд:

- Программ эзэмшигчийн зүгээс программыг хөгжүүлэхэд анхаарал хандуулж, санхүүгийн болон бусад талаар дэмжиж ажиллах,
- МУИС, Бизнесийн сургууль, Нягтлан бодох бүртгэлийн тэнхим болон бусад хамтран ажиллагч байгууллагууд программыг арилжааны эргэлтэнд оруулахад хамтран ажиллах хэрэгтэй гэсэн санал, зөвлөмжийг өгч байна.

## Ашигласан материал

1. 2007, 2008, 2009, 2010, 2012, 2013, 2014, 2015, 2017 онуудад Нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийн 2 жилийн эрх авсан байгууллагуудын жагсаалт.
2. Алтанзаяа, Г., & Чимгээ, Д. (2013). *Бүртгэлийн мэдээллийн систем*, Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр.
3. Батжаргал, Р. (2000). Нягтлан бодох бүртгэлийн бодлогын одоогийн байдал, түүнийг шинэчлэх шаардлага. *Эдийн засаг, онол практик*, 5, 29.
4. Сангийн яам (2011). *Нягтлан бодох бүртгэлийн программ хангамжид хяналт тавих тухай - Сангийн сайдын 2009.11.23-ны 252 дугаар тушаалын хавсралт*, Улсын үзлэгийн нэгдсэн дүн.
5. [www.mof.gov.mn](http://www.mof.gov.mn). Монгол Улсын Сангийн Яамаас гаргасан.
6. [www.monicsra.mn](http://www.monicsra.mn). Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институтээс гаргасан.